#чөлөөлье

ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ТАЛААР БАРИМТЛАХ

ӨМЧЛӨЛИЙН БОДЛОГО

2026.11.05

ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ШИНЭ ЭРХЗҮЙН ОРЧИН

#чөлөөлье

ХУУЛИЙН НЭР

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

ХЭРЭГЖИЖ ЭХЛЭХ ХУГАЦАА

2027.01.01

ӨМЧЛӨЛ

ТОДОРХОЙ БАЙДАЛ

ЗАСАГЛАЛ

МЭРГЭЖЛИЙН ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

ИЛ ТОД БАЙДАЛ

НЭЭЛТТЭЙ ХЯНАЛТ

ХАРИУЦЛАГА

БОДИТ ҮР ДҮН

#чөлөөлье

ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ТАЛААР БАРИМТЛАХ ӨМЧЛӨЛИЙН БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ БАТЛУУЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

7 дугаар зүйл.Төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлого

7.1.Төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.

7.2.Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Засгийн газрын гишүүдийн саналыг авч, нэгтгэн судалсны үндсэн дээр төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн5 4.1.8-д заасан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн боловсруулна.

7.3.Төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогод дараах зүйлийг тусгана:

7.3.1.төрийн өмчит компанийн хувьцаа эзэмших зорилго, хяналтын эрхийг хэрэгжүүлэх үндэслэл;

7.3.2.төрийн өмчит компанийн жагсаалт, хөрөнгийн багц мэдээлэл;

7.3.3.төрийн өмчит компанийн засаглалд оролцогч талуудын гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага;

7.3.4.төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн;

7.3.5.төрийн өмчит компани шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, өөрчлөлт, шинэтгэлийн төлөвлөгөө;

7.3.6.төрийн өмчит компанийн хувьцааг худалдах, түүнийг хэрэгжүүлэх арга, төлөвлөгөө.

7.4.Төрийн өмчит компанийн талаар баримтлах өмчлөлийн бодлогод энэ хуулийн 8.1-д заасан төрийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэлийг компани тус бүрээр тодорхойлж тусгана.

#ЧЛӨӨЛЬЕ

ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ТАЛААР БАРИМТЛАХ ӨМЧЛӨЛИЙН БОДЛОГЫН ТӨСЛИЙН БҮТЭЦ, АГУУЛГА

1.БОДЛОГЫН ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ
2.БОДЛОГЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ
3.БОДЛОГЫН ЗОРИЛТ
4.БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ, ҮЕ ШАТ

I. ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИХ ЗОРИЛГО, ХЯНАЛТЫН ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ

II. ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ЖАГСААЛТ, ХӨРӨНГИЙН БАГЦ МЭДЭЭЛЭЛ

III. ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

IV. БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН

V. ШИНЭЭР ҮҮСГЭН БАЙГУУЛАХ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ, ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

VI. ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ХУВЬЦААГ ХУДАЛДАХ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА, ТӨЛӨВЛӨГӨӨ

ХУУЛЬД ТУХАЙЛАН ЗААСАН МЭДЭЭЛЭЛ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА, ТӨЛӨВЛӨГӨӨ ЗЭРГИЙГ АГУУЛСАН 4 ХАВСРАЛТ.

БОДЛОГЫН ҮНДЭСЛЭЛ

“Алсын хараа – 2050”

5.2.19-т “Төрийн компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна.”

Шинэ сэргэлтийн бодлого

6.2.Засгийн газрын бүтэц, зохион байгуулалтад цогц шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгч, оновчтой бүтцийг тогтоон, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлнэ.

6.4.Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна.

Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл

7.3.5-д Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулна,

7.3.5.1-д Төрийн болон орон нутгийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлнэ.

7.3.5.2-т Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны бүртгэл, мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангана.

7.3.5.3-т Төрийн болон орон нутгийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлж, төрийн оролцоог бууруулна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр

3.1.2.4-т “Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олонулсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлнэ”, 3.3.3.1-д “Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлах, эрчим хүчний салбарыг чөлөөт зах зээлийн зарчимд шилжүүлж, үнэ тарифыг зохистой түвшинд хүргэн, цаашид тогтмол индексжүүлэх тогтолцоог нэвтрүүлж, салбарын эрх зүйн орчныг шинэчилнэ”, 4.1.4.2-т “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагааг явуулах тогтолцоог бүрдүүлэх,.

ТӨК-ИЙН ТАЛААР БАРИМТЛАХ ӨМЧЛӨЛИЙН БОДЛОГО

БОДЛОГЫН ЗОРИЛГО

#Чөлөөлье

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 7.3-Т ЗААСАН ШААРДЛАГА

01 ТӨК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИХ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ

 # Арилжааны ТӨК
 # Нийтийн үйлчилгээний ТӨК

02 ТӨК-ИЙН ЖАГСААЛТ, ХӨРӨНГИЙН БАГЦ МЭДЭЭЛЭЛ

 # 101 төрийн өмчит компани
 # нийт 60 их наяд төгрөгийн хөрөнгө

03 ЗАСАГЛАЛД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

 # Хувьцаа эзэмшигч, ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үүрэг, хариуцлага тодорхой болно

04 ТӨК-ИЙН ХУВЬЦААГ ХУДАЛДАХ АРГА, ТӨЛӨВЛӨГӨӨ

 # Эрдэнэс тавантолгой, Эрдэнэт үйлдвэр, МИАТ, Төрийн банк, Монголын хөрөнгийн бирж гэх мэт 20 ТӨК-ийн хувьцааг олон нийтэд санал болгоно.

05 ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

 # Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах замаар хувийн хэвшил дангаараа үр ашигтай ажиллах боломжтой зах зээлд төрийн оролцоог хязгаарлах.

06 ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН

 # ТӨК-ийн ангилал, онцлогт нийцсэн шалгууртай болно
 # ТӨК-ийн засаглалын үнэлгээг олон улсын жишигт хүргэнэ
 # Урт хугацааны тогтвортой үнэ цэн бүрдүүлэх

БОДЛОГЫН ЗОРИЛГО

ТӨК-ийн хувьцааг эзэмших зорилго, үндэслэл, өмчлөлийг хадгалах болон хэлбэр, хувь хэмжээг өөрчлөх чиглэлийг тодорхойлж, төрийн өмчийн хувьцааны багцын удирдлага, засаглал, хувьцааг худалдах ажиллагаанд нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх замаар **төрийн өмчийн үнэ цэн, эдийн засгийн үр өгөөж, нийтийн үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэхэд оршино.**

#ЧӨЛӨӨЛЬЕ

ТӨК-ИЙН ӨНӨӨГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2021-2025 ОНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ /нэгтгэсэн тайлан гаргадаг ТӨК-үүдийн хувьд/

	2021	2022	2023	2024	2025
Нийт хөрөнгө (их наяд ₮)	53.5	59.2	64.2	59.4	**60.0**
Нийт орлого (их наяд ₮)	10.6	14.6	23.6	25.9	**25.3**
Нийт зардал (их наяд ₮)	9.1	11.5	16.9	18.2	**22.6**
Цэвэр ашиг (их наяд ₮)	1.0	2.0	4.9	5.7	**1.7**
Ажилтан (мянган хүн)	53.3	56.9	58.1	59.7	**60.7**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

101 төк

ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИ

АРИЛЖААНЫ

43 төк

“АШИГТ АЖИЛЛАГАА, УРТ ХУГАЦААНЫ ҮНЭ ЦЭНЭ” ЧУХАЛЧИЛНА

- ✓ Компанийн оруулсан капиталын өгөөжийг капиталын жигнэсэн дундаж өртгөөс дээш түвшинд хүргэх, компанийн урт хугацааны үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой байна.
- ✓ Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт татах, хувьцаа эзэмшлийн бүтцийг төрөлжүүлэх, хувьцааг нийтэд санал болгох арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлнэ.

НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ

58 төк

“НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ЧАНАР” ЧУХАЛЧИЛНА

- ✓ Иргэдэд үйлчилгээг хүртээмжтэй, чанартай, тасралтгүй, боломжит бага зардлаар хүргэх зорилготой байна.
- ✓ Үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгаж, засаглалыг сайжруулах, өөрчлөн байгуулах хувилбарыг хуульд заасан шийдвэр, зөвшөөрлөөр хэрэгжүүлнэ.

#чөлөөлье

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ТӨР ЭНЭ КОМПАНИЙГ ЯАХ ГЭЖ ЭЗЭМШИЖ БАЙГАА ВЭ?

ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙГ АНГИЛАХ ШАЛГУУР

- ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦООНЫ ТҮВШИН
- ҮНЭ ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ, ТАТААС
- НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ
- АШИГТ АЖИЛЛАГАА, НОГДОЛ АШГИЙН ХЭМЖЭЭ
- СТРАТЕГИ, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЧ ХОЛБОГДОЛ

НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОМПАНИ - 58

Үр шимийг зөвхөн ашгаар хэмжихгүй

ХҮРТЭЭМЖ | НЭГЖ ӨРТӨГ | ЧАНАР | ҮР АШИГ

АРИЛЖААНЫ КОМПАНИ - 43

БИЗНЕСИЙН ЗАРЧМААР АЖИЛЛАНА

ҮР АШИГ | НОГДОЛ АШИГ | ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ

ӨӨР АНГИЛАЛ, ТӨРӨЛ БАЙХГҮЙ

Төрийн нэр барьж хувийн хэвшилтэй өрсөлдөн, алдагдлаа төсвөөр нөхүүлэх боломжгүй болно

ТӨК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИХ
ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ

#чөлөөлье

ТӨР КОМПАНИТАЙ БАЙХ ҮНДЭСЛЭЛ

ҮНДЭСЛЭЛ ХАНГАГДАХГҮЙ
→ ТАТАН БУУЛГАХ
→ ШИНЭЭР БАЙГУУЛАХГҮЙ

- **НЭГ ДЭХ ҮНДЭСЛЭЛ: НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**

  # Хувийн хэвшил дангаараа гүйцэтгэх боломжгүй, # Санхүүгийн үр ашиггүй нөхцөлд

- **ХОЁР ДАХЬ ҮНДЭСЛЭЛ: БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН АШИГЛАХ**

  # Үндэсний эдийн засгийн ашиг сонирхлыг хангах зорилгоор , # Төрийн нийтийн өмчид хамаарах

- **ГУРАВ ДАХЬ ҮНДЭСЛЭЛ: ЗҮЙ ЁСНЫ МОНОПОЛЬ**

  # Төрийн оролцоотой зүй ёсны монополь

- **ДӨРӨВ ДЭХ ҮНДЭСЛЭЛ: ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ**

  # Батлан хамгаалах, # Хил хамгаалах, # Харилцаа холбоо, # Хууль сахиулах, # Шүүхийн шийдвэр гүйцэтгэх

- **ТАВ ДАХЬ ҮНДЭСЛЭЛ: ХУУЛЬД ТУСГАЙЛАН ЗААСАН**

  # Тусгайлсан хуулиар ТӨК-тай байхаар зохицуулсан

#ЧӨлөөлье

#ТӨК-ИЙН ТАЛААР БАРИМТЛАХ ӨМЧЛӨЛИЙН БОДЛОГО

БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ, ҮЕ ШАТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

1-Р ҮЕ ШАТ
2027 ОН

01 ТӨК-ИЙН ҮНДЭСЛЭЛ, АНГИЛЛЫГ ТОДОРХОЙ БОЛГОХ

02 ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭГ ОЛОН УЛСЫН ЖИШИГТ НИЙЦҮҮЛЭХ

03 НОГДОЛ АШГИЙН НЭГДСЭН БОДЛОГОТОЙ БОЛОХ

04 ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ

05 НЭГДСЭН ЦАХИМ СИСТЕМД БҮРЭН ХАМРУУЛАХ

06 ТӨК-ИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАГЦЫН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

2-Р ҮЕ ШАТ
2028-2029 ОН

01 ТӨК-ИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ХУВЬЦААГ ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОХ

02 ТӨК-ИЙН ХУВЬЦААГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН БАГЦАД ТӨВЛӨРҮҮЛЭХ

03 БАГЦАД ХАМААРАХ ТӨК-ИЙН ҮНЭ ЦЭНИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

04 БАГЦАД ХАМААРАХ ТӨК-ИЙГ ҮЕ ШАТТАЙГААР ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОХ

05 ХОС-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТОГТВОРЖУУЛАХ

06 ХОС-ИЙН БАГЦАД ТӨК-ИЙН ХУВЬЦААГ НЭМЖ ОРУУЛЖ ЭЗЭМШЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭГ ОНОВЧТОЙ БОЛГОХ

3-Р ҮЕ ШАТ
2030 ОН

01 ТӨК-ИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ХУВЬЦААГ ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОХ

02 ОЛОН НИЙТЭД ХУВЬЦААГАА САНАЛ БОЛГОСОН ТӨК-ИЙН ТООГ 20 БОЛГОН НЭМЭГДҮҮЛЭХ

03 САНГИЙН БАГЦЫН ҮНЭ ЦЭН, ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, ӨГӨӨЖ, ХӨРВӨХ ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

04 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ

05 ӨМЧЛӨЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ

06 ДАРААГИЙН ҮЕ ШАТНЫ БОДЛОГЫН САНАЛ БОЛОВСРУУЛАХ

#ТӨСВӨӨС БИШ – ЗАХ ЗЭЭЛЭЭС ХӨРӨНГӨ ТАТНА

IPO-Д ЯАРАХГҮЙ – ЭХЛЭЭД ҮНЭ ЦЭНИЙГ ӨСГӨНӨ

#Чөлөөлье

ЗАСАГЛАЛ › ӨР, АВЛАГА › ИДЭВХГҮЙ ХӨРӨНГӨ › АУДИТ › МЕНЕЖМЕНТ › ҮНЭЛГЭЭ › ХӨРӨНГӨ ТАТНА

ҮНДСЭН ЗОРИЛГО

АРД ТҮМНИЙ ХӨРӨНГИЙГ **БУСДАД ЗАРАХ БИШ** › АРД ТҮМНИЙ ХӨРӨНГИЙГ **ҮНЭ ЦЭНТЭЙ БОЛГОХ**

01 ЗАСАГЛАЛ, ӨР, АВЛАГА, ИДЭВХГҮЙ ХӨРӨНГИЙГ ЦЭГЦЭЛНЭ

02 АУДИТ, МЕНЕЖМЕНТ, ҮНЭЛГЭЭГ ОЛОН УЛСЫН ТҮВШИНД ХҮРГЭНЭ

03 КОМПАНИЙН ҮНЭ ЦЭНИЙГ ӨСГӨСНИЙ ДАРАА ХӨРӨНГӨ ТАТНА

#ТӨК-ИЙН ТАЛААР БАРИМТЛАХ ӨМЧЛӨЛИЙН БОДЛОГО

ХУВЬЦААГ ХУДАЛДАХ АРГА, ТӨЛӨВЛӨГӨӨ

#чөлөөлье

БОДЛОГЫН ДАРААГИЙН ШАТ БОЛ ӨСӨЛТ

Дотоод | Олон улсын | IPO | IPO ГАРГАХ – 22 ТӨК | ХУВЬЦААГ САНАЛ БОЛГОХ – 3 ТӨК

ТӨК-ИЙН НЭР	ОДООГИЙН %	САНАЛ БОЛГОХ %	2030 ОНД ТӨРД ҮЛДЭХ %
ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР	100%	-	-
МОНГОЛРОСЦВЕТМЕТ	100%	10-33.3% хүртэл	66.7%
ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ	73.5%	-	-
БАГАНУУР	75%	24.0% хүртэл	51.0%
ШИВЭЭ-ОВОО	90%	39.0% хүртэл	51.0%
ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР	100%	10-33.3% хүртэл	66.7%
ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС	100%	10-33.3% хүртэл	66.7%
ТӨРИЙН БАНК	94.3%	-	-
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ	66%	-	-
МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	94.7%	43.7% хүртэл	51.0%
МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК	100%	-	-
БИОКОМБИНАТ	100%	10-33.3% хүртэл	66.7%

ТӨК-ИЙН НЭР	ОДООГИЙН %	САНАЛ БОЛГОХ %	2030 ОНД ТӨРД ҮЛДЭХ %
ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ	100%	66.0% хүртэл	34.0%
ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ	100%	49.0% хүртэл	51.0%
МИАТ	100%	49.0% хүртэл	51.0%
МОНГОЛ ШУУДАН	66%	32.0% хүртэл	34.0%

НЭГТГЭЖ 1 ТӨК БОЛГОН ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОХ

▪ ДУЛААНЫ 2-р ЦАХИЛГААН СТАНЦ ▪ ДУЛААНЫ 3-Р ЦАХИЛГААН СТАНЦ ▪ ДУЛААНЫ 4-р ЦАХИЛГААН СТАНЦ ▪ АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ▪ ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ ▪ ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ	100%	49.0% хүртэл	51.0%

ӨРСӨЛДӨӨНТ ХЭЛЦЛИЙН УР ДҮНД ХУДАЛДАХ

ЦЕМЕНТ ШОХОЙ	100%	51.0% хүртэл	49.0%
БАГАНУУР СУВИЛАЛ	100%	100.0% хүртэл	0%
МОНЦАХИМ	46%	46.0% хүртэл	0%

#ЧӨЛӨӨЛЬЕ

ЧӨЛӨӨЛЬЕ ЭХНИЙ ШАТНЫ ҮР ДҮН 2026 ОН

▼ 22.3% буурууллах арга хэмжээ авсан

130 › **101**

Компани, үйлдвэрийн газар

Арилжааны болон Нийтийн үйлчилгээний компани болгосон

61 › **31**

Үйлдвэрийн газар

Нийтийн үйлчилгээний байгууллага

16

ТӨК

4

Татан буулгасан

#ТӨК-ИЙН ТАЛААР БАРИМТЛАХ ӨМЧЛӨЛИЙН БОДЛОГО

ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БОДЛОГЫН ҮР ДҮН 2027-2030 ОН

▼ 20% бууруулах арга хэмжээ авна

85 › **36** **49**

ТӨК болгож бууруулна

АРИЛЖААНЫ КОМПАНИ

НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОМПАНИ

МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРТ СУУРИЛСАН ЗАСАГЛАЛ

ХҮН СОЛИХ БИШ – ТОГТОЛЦООГОО СОЛИНО

#Чөлөөлье

ЦАХИМ ШИЙДЭЛД СУУРИЛСАН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛНА

МЭРГЭЖЛИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫГ НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЧМААР ТОМИЛНО

УЛС ТӨРИЙН НӨЛӨӨЛЛӨӨС АНГИД ТОГТОЛЦОО БҮРДЭНЭ



45%

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД

2027.01.01

ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ХУУЛЬД ЗААСАН ШАЛГУУРААР ШИНЭЭР БҮРДҮҮЛНЭ

Компани тус бүрийн хувьцаа эзэмших зорилго, үндэслэлийг тодорхойлж, төрийн өмчит компанийн жагсаалтыг оновчтой болгоно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус байдал, мэргэшил, хариуцлагыг олон улсын жишигт (OECD) нийцүүлэн бэхжүүлнэ.

Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлагналын ил тод, нээлттэй байдлыг хангах, нэгдсэн цахим мэдээллийн санг бүрдүүлнэ.

Арилжааны төрийн өмчит компаниудын капиталын өгөөжийг капиталын жигнэсэн дундаж өртгөөс дээш түвшинд хүргэх, Нийтийн үйлчилгээний төрийн өмчит компаниудын нийтийн үйлчилгээний чанар, хүртээмж үр ашгийг дээшлүүлэх

#ЧӨлөөлье

ОЛОН НИЙТЭД ХУВЬЦААГАА САНАЛ БОЛГОХ ТӨК-ИЙН ТОО

20

3.3 дахин нэмэгдэнэ

ОЛОН НИЙТЭД ХУВЬЦААГАА САНАЛ БОЛГОХ ХӨРӨНГИЙН ДООД ХЭМЖЭЭ

35 → 4.5

их наяд ₮ — их наяд ₮

12.8%-ийг санал болгоно

НИЙТ ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЖ

8%

2.7 дахин сайжирна

ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЖ

10%

2 дахин сайжирна

ТӨК-ИЙНЗАСАГЛАЛЫН ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ

95%

Олон улсын жишигт нийцүүлнэ

ТӨК-ИЙН ТООГ

20%

бууруулна

#ТӨК-ИЙН ТАЛААР БАРИМТЛАХ ӨМЧЛӨЛИЙН БОДЛОГО

БОДЛОГЫН ҮР ДҮН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ТӨР АРИЛЖААНЫ БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХГҮЙ

100% төлөөлнө

ШУУДАН, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ТӨК ДАХЬ ТӨРИЙН ОРОЛЦООГ БУУРУУЛНА

49% төлөөлнө

АГААРЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ТӨК ДАХЬ ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООГ БУУРУУЛНА

49% төлөөлнө

ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЭЛЖ БУЙ ТӨК ДАХЬ ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООГ БУУРУУЛНА

49% төлөөлнө

УУЛ УУРХАЙ, ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ТӨК ДАХЬ ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООГ БУУРУУЛНА

34% төлөөлнө

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЖИЛ БҮР УИХ-Д ТАЙЛАГНАНА.

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД

БАЯРЛАЛАА!